

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-21</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>22-57</i>

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, чөлөөлөх санал	22-27
2.Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох саналыг зөвшилцөх тухай асуудал	27-29
3.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	29-53
4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлт	53-56
5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	56-57

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 08 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Амартүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Ц.Мөнх-оргил, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн.

Хуралдаанд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар оролцов.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, чөлөөлөх санал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигч Р.Батрагчаа, Б.Болдбаатар, Ц.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигч Рагчаагийн Батрагчаагийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, чөлөөлөх тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага өгөөгүй болно./15:16/

Д.Цогтбаатар: Нэр дэвшигч Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 7

Бүгд: 11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатарын талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигч Цэдэвийн Цолмонгийн талаар ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Нэр дэвшигч Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох саналыг зөвшилцөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор нэр дэвшигч О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор нэр дэвшигч Очирсүхийн Машбатын талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор Очирсүхийн Машбатыг томилохоор Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, мөн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Шүүхийн сахилгын хорооны гишүүн Д.Ариунтуяа, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, мөн газрын Бүртгэл мэдээлэл, технологийн албаны ахлах прокурор Д.Бөхчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан, Монголын өмгөөлөгчдийн холбооны тэргүүн Л.Данзанноров нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Энх-Амгалан /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 4 дэх заалтын 46.10 дахь хэсэг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, 2 дахь заалтын 32.2.4, 32.2.5 дахь заалтыг 32.8 дахь хэсэг болгон, 4 дэх заалтын 46.9 дэх хэсэг, 5 дахь заалтын 71.1.31 дэх заалтыг тайлбар болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.8.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34.9-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлнэ.”

“46.9.Шүүгч зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална.”

“Тайлбар:-Энэ хуульд заасан “Шүүхийн цахим платформ” гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	7
Бүгд:	11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар дээрх саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “давж заалдах, анхан шатны” гэснийг “Ерөнхий зөвлөлийн ажлын алба,” гэж өөрчилж, “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт “шүүгчид” гэсний дараа “болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэснийг “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалтын “шүүгчид” гэснийг “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэж, “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэсний дараа “, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэснийг “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэснийг “орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэж тус тус өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 12.1, 12.2 дахь хэсэг болгох:

“12.1.Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй эсхүл хаалттай явуулах эсэх асуудлыг энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

12.2.Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1.2 дахь заалт, 12.2 дахь хэсэг, 12.10, 12.13, 12.14 дэх хэсгийг тус тус өөрчлөн найруулж, 12.11 дэх хэсгийг хасах.

“12.1.2.шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх;”

“12.2.Нээлттэй явуулсан шүүх хуралдааны шийдвэрийг хэргийн оролцогч нарт гардуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн бусад шийдвэр, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэлийг албажиж гарснаас нь хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна.”

“12.10.Төрийн нууцад хамаарах хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хаалттай явуулахаар тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан нээлттэй байна.”

“12.13.Энэ хуулийн 12.10-т заасан шийдвэрт гомдол, хүсэлт гаргах, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх журмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуулиар зохицуулна.

12.14.Шүүх энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд төрөлжүүлэн архив, албан хэрэг хадгалалтын хугацааны турш, шүүх хуралдааны бичлэгийг Ерөнхий зөвлөлийн баталсан журамд заасан хугацаанд хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.5 дахь хэсгийн “заавал байршуулна” гэснийг “байршуулахтай холбоотой журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж, 12.1.1 дэх заалтын “хуульд заасны дагуу сонирхогч этгээд биечлэн болон цахимаар” гэснийг “хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу сонирхогч этгээд” гэж, 12.8 дахь хэсгийн “хэсэгчлэн хаахаас” гэснийг “зарим хэсгийг хаахаас” гэж тус тус өөрчилж, 12.3 дахь хэсгийн “биечлэн, эсхүл цахимаар”

гэснийг, 12.16, 12.17 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “заавал” гэснийг, мөн зүйлийн 3 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “48 дугаар” гэсний дараа “32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “32.2.2-г” гэснийг “32.2.2, 32.8-д” гэж,” гэж нэмж, “19.2.3” гэсний дараа “дахь заалтын “Хүрээлэнд” гэснийг “Шүүхийн академид” гэж” гэж, мөн зүйлийн “Хүрээлэн” гэснийг “Шүүхийн академи” гэснийг “Хүрээлэнгийн” гэснийг Шүүхийн академийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Найруулгын санал:

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг зүйл бүрээр хэлэлцэж, санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах,” гэж нэмж, 2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь хэсгийн “хаалттай” гэснийг “нээлттэй, эсхүл хаалттай” гэж өөрчлөх:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

“2.1.хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс хүсэлт гаргасан бол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлд 6 дахь хэсэг болгох:

“6.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан албаны нууцыг задруулахгүй байх баталгааны зохицуулалт шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахад хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын мөн зүйлийн гэсний дараах “2” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7.5, 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.5, 7.6, 7.7 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 5, 6, 7, 8 дахь заалт, 4 дэх заалтын 75⁶ дугаар зүйлийн 75⁶.4.3, 75⁶.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“7.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болох бөгөөд шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна. Цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

7.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн мэдэгдэх хуудас, тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийг цахимаар хөтлөх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, хуульд заасан бусад этгээдэд танилцуулах, гардуулах, эрх, үүрэг тайлбарлах, нэхэмжлэл, бие даасан шаардлага, хэргийн

оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, нотлох баримтыг танилцуулах ажиллагааг шүүхийн цахим платформын ашиглан цахимаар явуулж болно.

7.7.Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

8.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

8.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

8.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

8.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.”

8.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “нэрийг” гэснийг “гарчгийн” гэж, “өөрчлөн найруулсугай” гэснийг “өөрчилсүгэй” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8.5 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөгдөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-10¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 10¹.1, 10¹.2 дахь хэсэг болгох:

“10¹.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна.

10¹.2.Цаасан баримтыг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлж, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, мөн танхимын шүүгч Н.Баярмаа нар тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11

Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 32.9, 32.10, 32.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32.9 дэх хэсэг болгох, мөн зүйлийн 4, 5, 6 дахь заалтыг тус тус хасах:

“32.9.Шүүх цахим баримт бичгийг эргэлзээтэй гэж үзвэл энэ хуульд заасны дагуу шаардлагатай ажиллагаа хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10^{1.6} дахь хэсгийн “үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем” гэснийг “эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн үүсгэсэн

бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар,” гэж өөрчилж, 10¹.5, 10¹.7, 10¹.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3, 5, 6, 7 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн “гардуулна.” гэсний дараа “Цахим нэхэмжлэлийг хариуцагчид энэ хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна.” гэж, 57.2 дахь хэсгийн “ирүүлнэ.” гэсний дараа “Цахимаар гаргасан хариу тайлбарыг тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэж, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “үүрэгтэй” гэсний дараа “Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхээс цахим системээр мэдэгдэл илгээснээр товыг мэдэгдсэнд тооцно” гэж,” гэснийг, “108.4 дэх хэсгийн “гардан авна.” гэсний дараа “Цахимаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-д заасны дагуу гардуулна” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/“9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

9.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

9.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

9.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

9.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

9.4.Энэ хуулийн 9.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.

9.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлж, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа нар тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “цахим шуудан” гэснийг “энэ хуулийн 59.12-т заасны дагуу гэж,” гэснийг хасаж, “шаардлагатай тохиолдолд” гэснийг “эсхүл” гэж тус тус” гэснийг “хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд” гэснийг “хүргүүлэх, эсхүл” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалтын “байгууллага,” гэснийг,” гэснийг, “75 дугаар зүйлийн 75.2.6,” гэснийг тус тус хасаж, “50.4-т” гэсний өмнө “энэ хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “байгууллагын нууц,” гэснийг “хэсгийг” гэснийг “хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийг” гэж өөрчилж 6 дугаар зүйлд зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, 2 дахь заалтын 2.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “эрүүгийн” гэснийг “зөрчлийн” гэж, “хүргүүлнэ” гэснийг “хүргүүлж болно” гэж өөрчлөх:

“3.Хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн нэгдсэн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэргийн баримт бичиг, материал нь шүүхийн нэгдсэн цахим платформын шаардлагад нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтад “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх,” гэж заасны “... үйлдвэрчний эвлэлийн ..., үйлдвэрчний эвлэлийн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол...-ын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 8

Бүгд: 11

27.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 44 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 17 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 08 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Ширнэнбаньдын Адьшаа, Норовын Алтанхуяг, Лхагвын Мөнхбаатар, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Баттөмөрийн Энхбаяр, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гэсэн гишүүдийн ирцтэйгээр хурлын ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1. Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, чөлөөлөх санал,

2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай санал,

3. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 4 гишүүн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлт. Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай,

5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналаа өгье. Нэрээ өгье. Алга байна.

Тэгэхээр ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

I дүгээр асуудал.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай саналыг хэлэлцье.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцье.

Нэр дэвшигч Рагчаагийн Батрагчаагийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын

дарга Янгугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргын микрофоныг өгье. Хэддүгээр микрофон байна. 2 дугаар микрофон.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар, 14 дүгээр захирамжаар Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Бэсүд овогтой Рагчаагийн Батрагчаа нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 46 настай, эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Батрагчаа нь 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 77 дугаар дунд сургууль, 1999 онд Отгонтэнгэр Их сургуулийг Олон улсын эрх зүйн бакалаврын зэргээр, 2002 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн магистрын зэрэгтэй тус тус төгссөн. Англи, орос хэлтэй.

Нэр дэвшигч Батрагчаа 1999-2000 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа дахь сум дундын прокурорын газарт хяналтын прокурор, 2001-2003 онд Түшиээ Хууль зүйн дээд сургуульд Эрх зүйн танхимын багш, 2005-2006 онд Ир Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Берримен хуулийн фермд туслах хуульчаар, 2007-2008 онд Датамо, Кью жи экс компаниудад хуульч, 2008-2016 онд Эй энд Эй Глобал хуулийн фермийн захирал өмгөөлөгчөөр, 16-19 онд Төрийн орон сууцын корпорацын Захиргаа санхүүгийн газрын даргаар, 19-20 онд Нийслэлийн засаг даргын Тамгын газрын даргаар, 20-22 онд ЭХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын даргаар, 2022-24 онд

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргаар, 24 оны 01 сараас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж байгаа туршилагатай бөгөөд үүнээс хуульч мэргэжлээр 17 жил ажилласан байна.

Нэр дэвшигч Рагчаагийн Батрагчаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан боловсролыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хуулийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, хууль зүйн улс төрийн өндөр мэргэжилтэй байх шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал болгож байна. Нэр дэвшигч Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Содбаатар даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү? Асуулт алга байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Алга байна.

Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Рагчаагийн Батрагчааг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулъя.

Манайхан бүгд байна уу? Ганбат гишүүн үг хэлж байя. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн цэцэд бол их боломжийн хүмүүсийг нэр дэвшүүлсэн байна гэж үзэж байна.

Ер нь шударга нь дээр. Манай АН-ын бүлэг бол бас хуралдаад бүлгээрээ бас энэ тэр томилгоонуудыг бас ярилцах ёстой гэж үзэж байгаа юм. Тийм учраас АН-ын бүлгээс завсарлага хүсэж байна. Энэ асуудал дээр.

Д.Цогтбаатар: Энэ чинь танайхаас завсарлага авахын тулд бүлгийн чинь дарга тэгвэл энэ асуудлыг тавих ёстой шүү дээ. Зарчмын хувьд, тийм.

Дэгийн хуулиараа танай авах субъект нь санал тавиагүй учраас боломжгүй байна.

Санал хураалтаа явуулъя.

Дэлгэрсайхан гишүүн горимын санал гаргая.

Б.Дэлгэрсайхан: Миний карт бүр орсон үгүй.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн Дэлгэрсайхан гишүүний саналаар санал хураалт явуулъя. Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

54 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүй болголоо. Одоо ингээд түрүүн уншиж танилцуулсан саналын томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатарын танилцуулгыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргын микрофон.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1. 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар захирамжаараа Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Хиад овогтой Бямбадоржийн Болдбаатар нь 68 онд Улаанбаатар хотод төрсөн, 56 настай, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Болдбаатар 86 онд Улаанбаатар хотын 10 жилийн 33 дугаар дунд сургууль, 92 онд Москва хотын Авто замын дээд сургуулийг инженерээр, 2001 онд МУИС-ийг Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавраар төгссөн. Орос англи хэлтэй.

Болдбаатар нь 90-91 онд Гадаадад суралцагч Монгол оюутны холбооны ерөнхийлөгчөөр, 92-97 онд Боловсрол компанид, 97-оос 2004 онд Түшээ дээд сургуульд гүйцэтгэх захирал багшаар, 2004-өөс 5 онд УИХ дахь Эх орон ардчиллын эвслийн бүлгийн ажлын албаны ахлагч, 2005-2006 онд УБТЗ-д Хууль зүйн албаны даргаар, 2006-2010 онд УИХ дахь АН-ын зөвлөлийн бүлгийн Ажлын албаны даргаар, 2012-16 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар, 17-21 онд Монгол Улсаас Бүгд найрамдах Болгар Улсад суух ЭСЯ-нд зөвлөхөөр, 2021 оноос Улсын Их Хурлын Тамгын

газарт зөвлөх, газрын даргаар ажиллаж байна. Хуульч мэргэжлээр 19 жил ажилласан байна.

Нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатар нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хууль зүйн улс төрийн өндөр мэргэжилтэй шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон Бямбадоржийн Болдбаатарыг дэмжиж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Нэр дэвшигчийн танилцуулгыг та бүгдэд тараасан байгаа. Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгье. Адьяаа гишүүн байна. Адьяаа гишүүнээр тасаллаа. Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлсэн хүмүүсийн тухай асуудлыг бид өнөөдөр хэлэлцэж байна. Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн энэ хүмүүсийн тухайд мэдээж Содбаатар даргын танилцуулж байгаагаар бас хууль зүйн өндөр боловсрол, мэдлэгтэй ийм бас цэцийн гишүүний байх ёстой шаардлагыг хангасан гэж ойлгож байгаа.

Болдбаатар даргын тухайд ер нь хаана ажиллаж байсан, Их Хурлын Тамгын газрын дарга байсан гэдэг мэдээлэл байсан. Энэ хэдий үед Их Хурлын Тамгын газрын дарга байсан юм. Тэгээд цаашилаад энэ ҮХЦ гэдэг энэ байгууллага бол өнөөдөр хууль, эрх зүйн хувьд, үнэлэмжийн хувьд энэ шүүх эрх мэдлийн ойлголтын тухайд маш их маргаантай ийм асуудлууд байдаг. Энд ер нь ямар бодолтой байгаа юм? Цэц

өнөөдөр улс төрийн захиалгаар улс төрийн бодлогоор ингэж асуудалд ханддаг ийм байгууллага болсон гэдэг ийм асуудал яригддаг ийм жишээнүүд ч байгаа. Энэ дээр ер нь ямар бодолтой байна?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон өгье.

Я.Содбаатар: Адьяаа гишүүний асуултад хариулъя. Болдбаатар бол 2012-16 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, төрийн албан хаагч. Одоо Улсын Их Хурлын Тамгын газарт Хууль, эрх зүйн газрын даргаар ажиллаж байгаа ийм албан хаагч байна.

Ер нь бол Цэц дээр бид нар аль болох мэргэжисэн, эрх зүйч хүмүүсийг дэвшүүлье гэж байгаа. Та бүхэн Цэцэд бол Монгол Улсын Ерөнхийлөгчөөс, Дээд шүүхээс, Их Хурлаас 3, 3 хүн томилогддог.

Тэгээд энэ удаа бол манай институтээс 2 хүнийг дэвшүүлж байгаа. Хоёулаа, хуульч мэргэжилтэй, энэ чиглэлээрээ их, дээд сургуульд багшилж байсан, төрийн захиргааны алба хашиж байсан, ийм мэргэжлийн эрх зүйч, хуульч хүмүүсийг дэвшүүлж байгааг тодотгож хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ингээд асуулт асууж дууслаа.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Бямбадоржийн Болдбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

72 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлаас ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцье. Нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Занданишатар дарга өөрөө, эс үгүй бол Мөнхбаатар дарга танилцуулчих. Тийм. Ингээд нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танилцуулна. Их Хурлын даргын микрофоныг өгье.

Г.Занданишатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд ээ, Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган дэвшүүлбэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшүүлэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гишүүдийн олонх дэмжиж, Хууль зүйн байнгын хороонд танилцуулж байна.

Цэдэвийн Цолмонг дэвшүүлэхдээ бол:

1 дүгээрт, Цэдэвийн Цолмонгийн онол, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын мэдлэг, ур чадвар,

2 дугаарт, Хууль тогтоох байгууллагад ажилласан туршилага, ур чадвар,

3 дугаарт, Гүйцэтгэх засаглал буюу Засгийн газрын түвшинд ажилласан ажлын туршилага,

4 дүгээрт, шүүх байгууллагад ажиллаж байсан туршилагыг үндэслээд хууль зүйн өндөр мэргэжилтэй, улс төр, хуулийн салбарт ажилласан туршилагатай ийм онол практикийн мэдлэг боловсролтойг харгалзан үзэж,

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дэвшүүлж байна.

Цэдэвийн Цолмон бол Улаанбаатар хотын 52 дугаар дунд сургуулийг төгссөн. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, Их Британи Улсын Эксетерийн Их сургуулийн хууль зүйн магистрын зэрэгтэй.

2013-14 онд бол АНУ-ын Нью-Йорк хотын Колумбийн Их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэйгээр тус тус төгсөөж хамгаалсан.

Ажлын гараагаа 93-94 онд Улсын Их Хурлын Тамгын газарт мэргэжилтнээр эхэлж, 98-аас 2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн танхимын багш, 2004 оноос 2013 он хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, 2016-аас 19 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар, 2020-оос 22 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирлаар ажиллаж байсан. Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч, арбитрчаар ажиллаж байгаа. Ийм туршилага мэдлэг, чадвартай, мэргэшсэн хуульч хүн байна.

Ингээд Хууль зүйн байнгын хорооны гишүүд та бүхнийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Их Хурлын даргад баярлалаа.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Байхгүй байна.

Нэр дэвшигчид хандан үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Алга байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд орж ирж байрандаа суугаарай.

Тэгвэл дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

Ингээд нэр дэвшээд Байнгын хороогоор дэмжигдсэн гишүүддээ ямар ч гэсэн байнгын хорооныхоо зүгээс бол баяр хүргэе. Тэгээд ажилд нь амжилт хүсье.

15.34 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал.

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчид нэр дэвшигч Очирсүхийн Машбатын танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргын микрофоныг өгье. 2 дугаар микрофон.

Я.Содбаатар: *Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46*

дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Очирсүхийн Машбатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох асуудлыг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд санал болгон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Цагаан овогтой Очирсүхийн Машбат нь 1981 онд Дорноговь аймагт төрсөн. 43 настай, ам бүл 5.

Машбат нь 1998 онд Дорноговь аймгийн ЕБС, 2002 онд Чингис хааны нэрэмжит Их Засаг Их сургуулийн эрх зүйч мэргэжлээр, 2005 онд Их Засаг Их Сургуульд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2005 онд СЭЗДС-ийн бизнесийн удирдлагаар, 2007 онд АНУ-ын Колорадогийн их сургуульд суралцаж, Эрүүгийн эрх зүйд суурилсан шинжлэх ухааны удирдлагын магистрын зэрэг хамгаалсан байна.

Машбат нь 2003-2005 онд Улсын Их Хурлын Тамгын газарт туслах ажилтан, ажилтнаар, 2008-2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт мэргэжилтнээр, 2009-2013 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн даргаар, 2015-2017 онд УЕПГ-т хяналтын прокуророор, 2017-2019 онд Нийслэлийн прокурорын газарт хэлтсийн дарга, ахлах прокурор, 2019-өөс 20 онд Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга, ахлах прокуророор, 2020-2024 онд ЗГХЭГ-ын Шадар сайдын зөвлөхөөр мөн Ерөнхийлөгчийн Тамгын газарт Хуулийн бодлогын газрын даргаар тус тус ажиллаж байсан. 24 оны 01 дүгээр сараас Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, ахлах прокуророор ажиллаж байгаа туршилагатай бөгөөд 2004 онд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ авсан. Хуульч мэргэжлээр 20 жил ажиллаж байна.

Машибат нь Прокурорын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-д заасан хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, 35 насанд хүрсэн прокурорыг УЕП, түүний орлогчоор томилно гэсэн шаардлагыг бүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Очирсүхийн Машибатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу зөвшилцөхөөр хүргүүлж байгааг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Содбаатар даргад баярлалаа.

Ингээд Ерөнхийлөгчөөс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг та бүгдэд тараасан байгаа. Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрээ өгнө үү. Байхгүй байна.

Би өөрөө нэг товчхон үг хэлчихье. Ер нь энэ 20 жил энэ салбартаа ажилласан мөн түүнчлэн зөвхөн хууль, хяналтын байгууллагуудын тогтолцоогоор биш ер нь төрийн бас захиргааны байгууллагуудад ажиллаж байсан гэдэг бол энэ хангалттай төрийн үйл ажиллагааны энэ туршилага суусан хүн байна. Тэгээд АНУ-д Колорадо сургууль төгссөн, зэрэг хамгаалсан байна. Энэ ингээд бүгдийг аваад үзэхэд яах аргагүй энэ ажлынхаа шаардлага тавигдах энэ шалгуурыг даваад орж ирж байгаа бас хүн байна. Залуу хүн байна.

Монгол Улсын хууль, хяналтын байгууллагад бол үнэхээр энэ ард түмнээс яриад байгаа юм бол шударга ёс гэдэг асуудал. Хуулийг үнэн сэтгэлээсээ

яг дагаж мөрдөх, тэгээд би танд нэг л юм захимаар байна. Монгол Улс чинь жижиг улс. Ингээд л танаас цааш энэ хуулийг сахиулах өөр хүн байхгүй шүү гэдэг ойлголттойгоор, сэтгэлтэйгээр хандаж ажиллаарай, ажилдаа. Өөрөөр хэлбэл дараагийн шатад энэ нь ингээд засагдаад явах юм чинь гэдэг нэг ийм хандлагаар юм уу, аливаа хүний хувь заяа шийдэх асуудал дээр материалтайгаа дутуу танилцаад ч юм уу, ийм хөнгөн хуумгай хандсан ийм хандлага 1 дүгээрт, байж болохгүй.

2 дугаарт, өшөө энэ дээр юуг хэлмээр байна гэхээр хүний эрхийн мэдрэмжтэй энэ дээр онцгой анхаарч ажиллаарай. Яагаад гэвэл хүний эрх хамгийн их зөрчигдөж байгаа газрууд бол хууль хэрэгжих байгууллагууд. Хууль хяналтын байгууллагууд. Төрийн нэр барьж хүний эрх зөрчөөд байгаа тохиолдлууд олон байгаа гэж иргэд яриад байгаа шүү.

Тэгэхээр та хууль хяналтын манаанд зогсоно гэдэг бол хүний эрхийн манаанд зогсож байгаа гэсэн үг. Нээрээ яах аргагүй эргэлзээгүй буруу юм хийсэн хүн бол гарцаагүй шийтгэл хүлээдэг зарчим үйлчлэх ёстой.

Тэгэхдээ тэр эргэлзэх, хийгээгүй байвал яах вэ гэдэг талд нь бас бодолцож, тэр хүний эрх гэдэг юмыг хэрэгжиж байгаа процесс нь яг тан дээр, таны энэ үзэг хөдлөх төдийд энэ асуудал чинь байнга хөндөгдөж байгаа гэдгийг бодож анхаарч ажиллаарай гэж захимаар байна.

Ингээд тэгвэл санал хураалт явуулъя. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор Очирсүхийн Машибатыг томилохоор Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулна. Байнгын хорооны дарга Цогтбаатар танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатарт баярлалаа.

15.41 цаг

Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 4 гишүүн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна. Сандаг-Очир гишүүн яг хажуугийн нөгөө сонсголд сууж байна. Орж ирээд асуудлаа танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Г.Занданишатар, Н.Учрал, Д.Тогтохсүрэн нарын гишүүдээс 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 84 дүгээр захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Энх-Амгалан болон холбогдох бусад гишүүд албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 27, 29-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг хэлэлцэж, зарчмын зөрөөтэй саналын томъёолол 7, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх 22 санал, төслийн бүтэц нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх 1 саналын томъёоллыг хэлэлцэн дэмжиж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно

Тухайлбал, шүүхийн хуралдааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийт үнэн бодит мэдээллийг авах боломжийг тэгш хангах зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа нь нууцын холбогдох хууль тогтоомжийг шүүхийн шатад хэрхэн зохицуулах талаар уялдаа холбоог хангаж нарийвчлан тусгалаа.

Шүүх Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гутгаар түшээ, дөтгөөр түшээ, 5 дугаар түшээ зэрэг дэвтэй байна гэснийг өөрчлөн найруулж, шүүгчид зэрэг дэв олгох журмыг УИХ батлахаар, шүүхийн цахим платформ гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж, мэдээллийн

сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ гэсэн тайлбарыг төсөлд тусгах.

Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34-ийн 9-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлэх, иргэд нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтлан шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох зэрэг болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Д.Мөнхтуяа Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, Б.Батцэрэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Н.Баярмаа Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч, Л.Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Д.Ариунтуяа Шүүхийн

сахилгын хорооны гишүүн, С.Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Ц.Батболд Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Б.Оюунгэрэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч, Д.Баянжаргал Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Б.Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Д.Эрдэнэчимэг Улсын дээд шүүхийн Сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал, Ж.Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Д.Бөхчулуун Улсын ерөнхий прокурорын газрын Бүртгэл, мэдээлэл, технологийн албаны ахлах прокурор, Л.Данзанноров Монголын өмгөөлөгчдийн холбооны тэргүүн гэсэн ийм албан тушаалтнууд ажлын хэсэгт орж ажилласан байна.

Тэгээд энэ хуралдаанд ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулт гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Нэг саналтай байгаа.

1.Шүүхийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 4 дэх заалтын 46.10 дахь хэсэг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, 2 дахь заалтын 32.2.4, 32.2.5

дахь заалтыг 32.8 дахь хэсэг болгон, 4 дэх заалтын 46.9 дэх хэсэг, 5 дахь заалтын 71.1.31 дэх заалтыг тайлбар болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.8.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34.9-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлнэ.”

“46.9.Шүүгч зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална.”

“Тайлбар:-Энэ хуульд заасан “Шүүхийн цахим платформ” гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ.”

Энэ юугаар томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ миний өөрийн юу гацчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Тэгээд энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний уншиж танилцуулсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “давж заалдах, анхан шатны” гэснийг “Ерөнхий зөвлөлийн ажлын алба,” гэж өөрчилж, “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт “шүүгчид” гэсний дараа “болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэснийг “72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалтын “шүүгчид” гэснийг “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтанд” гэж,” гэж, “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэсний дараа “, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэснийг “85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “орон тоог” гэснийг “орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг” гэж,” гэж тус тус өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тэгэхээр энэ хуулийн төслийн ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 4 саналтай байгаа.

3. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 12.1, 12.2 дахь хэсэг болгох:

“12.1.Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй эсхүл хаалттай явуулах эсэх асуудлыг энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

12.2. Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод явуулна.” Санал хураалт.

Мөнхцэцэг гишүүн микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Сая санал хураалтын үед миний төхөөрөмж гацсан учраас энэ саналыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Тэр томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1.2 дахь заалт, 12.2 дахь хэсэг 12.10, 12.13, 12.14 дэх хэсгийг тус тус өөрчлөн найруулж 12.11 дэх хэсгийг хасах.

12.1.2. шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах эсхүл олон нийтэд дуу дүрсний бичлэгээр хүргэх,

12.2. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1.2 дахь заалт, 12.2 дахь хэсэг, 12.10, 12.13, 12.14 дэх хэсгийг тус тус өөрчлөн найруулж, 12.11 дэх хэсгийг хасах.

“12.1.2.шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх;”

“12.2.Нээлттэй явуулсан шүүх хуралдааны шийдвэрийг хэргийн оролцогч нарт гардуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн бусад шийдвэр, шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэлийг албажиж гарснаас нь хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд ил тод, нээлттэй байршуулна.”

“12.10.Төрийн нууцад хамаарах хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хаалттай явуулахаар тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан нээлттэй байна.”

“12.13.Энэ хуулийн 12.10-т заасан шийдвэрт гомдол, хүсэлт гаргах, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх журмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуулиар зохицуулна.

12.14.Шүүх энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, энэ хуулийн 12.1.3-т заасан цахим мэдээллийн санд төрөлжүүлэн архив, албан хэрэг хадгалалтын хугацааны турш, шүүх хуралдааны бичлэгийг Ерөнхий зөвлөлийн баталсан журамд заасан хугацаанд хадгална.” Санал хураалт

54,5 хувиар санал дэмжигдлээ.

5. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.5 дахь хэсгийн “заавал байршуулна” гэснийг “байршуулахтай холбоотой журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж, 12.1.1 дэх заалтын “хуульд заасны дагуу сонирхогч этгээд биечлэн болон цахимаар” гэснийг “хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу сонирхогч этгээд” гэж, 12.8 дахь

хэсгийн “хэсэгчлэн хаахаас” гэснийг “зарим хэсгийг хаахаас” гэж тус тус өөрчилж, 12.3 дахь хэсгийн “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг, 12.16, 12.17 дахь хэсгийг тус тус хасах. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

6. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “заавал” гэснийг, мөн зүйлийн 3 дахь заалтыг тус тус хасах. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэлтсийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай.

Төслийн 4 дүгээр зүйлийн “48 дугаар” гэсний дараа “32 дугаар зүйлийн 32.3 дахь заалтын “32.2.2-т” гэснийг “32.2.2, 32.8-д” гэж,” гэж нэмж, “19.2.3” гэсний дараа “дахь заалтын “Хүрээлэнд” гэснийг “Шүүхийн академид” гэж” гэж, мөн зүйлийн “Хүрээлэн” гэснийг “Шүүхийн академи” гэснийг “Хүрээлэнгийн” гэснийг Шүүхийн академийн” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

Учрал гишүүн санал гаргах уу?
Учрал гишүүний микрофоныг өгье.

Н.Учрал: Энэ сая дэмжсэн боловч дэмжээгүй гээд гарчихлаа. Дахиж санал хурааж гэж өгнө үү гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд түрүүний томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт саналгүй байна.

Тэгвэл хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан найруулгын 1 саналтай байна. Саналыг уншиж танилцуулъя.

Найруулгын санал. 1. Төслийн дараах зарчмын зөрөөтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 2 саналтай байгаа.

2. ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах,” гэж 2 дахь хэсгийг хасах. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 11.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.”. Санал хураалт.

Санал хураалтыг түр зогсооё. Учрал гишүүний микрофоныг өгье. Учрал гишүүний микрофон.

Н.Учрал: Энэ төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр бас нэлээдгүй ажлууд өрнөж байгаа. Гэхдээ яг ингээд энэ амьдрал дээр ирэхээрээ ихэнх бараг л төрийн алба бол бүхэлдээ нөгөө бичгээр материалыг нь нэхдэг. Тэгээд бичгээр гаргаад өгөхгүйгээр магадгүй нөгөө и-Монгол дээр байгаа ингээд бичиг баримт лавлагаагаа үзүүлэхээр заавал биетээр нь үзмээр байна гээд байдаг.

Тэгээд яагаад биетээр нь үзэх гээд байгаа юм бэ энэ чинь утсан дээр аппликэйшн дээр ингээд байна шүү дээ гэхээр энэ эрх зүйн үр дагавартай.

Хэрвээ ямар нэгэн асуудал үүсээд эрх зүйн үр дагавар үүсвэл шүүх дээр очно гэж байгаа. Тэгэхээр ер нь бол цахимжилт явж явж байгаад шүүх дээр ирдэг учраас хүн нотариат ч гэсэн өнөөдөр нотариатаар батлах гээд байгаа нь буруу бас биш л дээ. Тэр чинь 2 хүн хоорондоо худалдах, худалдан авах гэрээ хийгээд дунд нь нэг гэрч байгаа тамгалах ёстой. Нөгөө иргэний үнэмлэхээ нотариатаар хэн нэгэн хүн гэрчлэх ёстой. Тэгэхгүй бол шүүх дээр ирээд энэ чинь бас эрх зүйн үр дагавартай гээд.

Тэгээд бид бол өнгөрсөн хугацаанд Дээд шүүхтэй, энэ ШЕЗ-тэй энэ цахимжилтын асуудлаар нэлээдгүй олон уулзалт хийсэн. Тэгээд нөгөө дүрэм журмын түгжээг гаргах гээд 109 хууль гээд энэ эрүүгийн процесс, иргэний процесс, захиргааны процессын хууль дээр энэ цахим хэлбэрээр байж болно гэдгийг нээе ээ гэж байхад шүүх бид нар өөрсдөө шүүхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үеэрээ энэ асуудлыг нэг мөр шийдье ээ гээд. Тэгээд сая энэ Их Хурлын даргын энэ санаачилж байгаа хууль дээр энэ асуудлууд тусаж байгаа гэж би ойлгож байгаа.

Гэхдээ энэ хууль дээр дандаа нэг ийм үг явж байгаа. Цаасан болон цахим хэлбэртэй байж болно гээд. Тэгээд цаасан болон цахим хэлбэр гэдэг бол хоёуланг нь нэхэж байгаа л гэсэн үг. Нөгөө 109 хууль дээр цаасан эсхүл цахим хэлбэртэй байж болно гэдгээр томъёолсон. Одоо цаасан болон цахим хэлбэртэй байж болно гэхээр яг хуулийг хэрэглэхдээ бол юу гэж ойлгож байна вэ гэхээр цахимаар нөгөө бичиг хэрэг материал нь бүрдсэн бол түүнийгээ хэвлээд хадгалаад, давхар сейфэд хийнэ ээ л гэсэн яг л ийм л ойлголт уншигдаад байгаа байхгүй юу, эндээс.

Тэгэхээр цаасан болон цахим хэлбэртэй байж болно гэдэг энэ томъёоллоо нэлээд ойлгомжтой болгохгүй бол ингээд хууль батлагдчихна.

Тэр 25 он хүртэл ингээд нэг цаасан баримт бичигтэй явж байгаад тэгээд 25 оны 1 сараас цахим хэлбэр лүү шилжих гэхээр яг энэ хуулийн зохицуулалт дээр нь энэ их тийм ойлгомжгүй байдлаар ингээд тусчихсан. Тэгэхээр үүнийг нэлээд базаад шүүхийнхэн бол өөрсдөө тайлбарлах ёстой юм байна.

Дээрээс нь ер нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно гэж томъёолох нь ер нь бас зөв үү. Цаасан эсхүл цахим хэлбэртэй байж болно гэвэл эсвэл цаасан, эсвэл цахим сонголт өгч байгаа. Цаасан болон цахим хэлбэр гэхээр хоёуланг нь нэхээд байгаа юм.

Тэгэхээр нөгөө төрийн алба чинь бичиг цаас солилцоод давхар хэвлээд хадгалаад байхаар цахимжилт чинь бид нарын амьдралд бүр хүнд суртал үүсгээд байна гээд төрийн албан хаагч нар бухимдаад байх нь аргагүй байхгүй юу. Тэгэхээр цаасан эсхүл цахим хэлбэртэй байж болно гэдэг байдлаараа томъёолоод явж болох уу? Жишээ нь нөгөө Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль дээр цаасан баримт бичиг, цахим баримт бичиг зөрөх юм бол цаасыг нь барина гэдэг ганцхан зохицуулалт байсан. Түүнээс болоод нөгөө цахимаар хоорондоо солилцож байсан бичгүүдийг нь хэвлээд, хадгалаад байдаг байсан, төрийн алба. Сая цаасан байна уу, цахим байна уу хамаагүй тухайн бичиг баримт анх цаасаар үүссэн үү, цахимаар үүссэн үү гэдгээс нь шалтгаалаад архивлаж болдог. Ийм хуультай болсон шүү дээ.

Түүнээс хойш төрийн алба заавал нөгөө цахимаар үүсчихсэн бичгийг анхнаасаа цаасаар үүсчихсэн цахимаар үүсчихсэн бичгийг хэвлэж хадгалах шаардлагагүй юм гээд цахимаар нь архивлаад дижитал архив гэдэг ойлголт үүсчихсэн. Түүн шиг яг энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсэж байгаа нийт баримт бичиг хэргийн материал яг энэ хуулийг харахад бол цаасан, цахим, аль алианаар нь

хадгалаад л явах юм байна л гэдэг ийм ойлголт үүсгэж болно.

Бид нар зүгээр Их Хурал дээр өнөөдөр ингээд мэдээж ингээд 25 онд 01 сарын 01-нээс цахим руу шилжинэ гээд ийм гоё ярьж болох ч гэсэн яг амьдрал дээр нөгөө шүүгч нар хууль хэрэглээд эхлэхэд энэ чинь цаасан болон цахим хэлбэртэй буюу хоёулаа байх ёстой шүү дээ. Цахим нь байгаад цаасан нь алга байна л гэдэг ийм асуудал үүсэх учраас нөгөө л нөгөө хүнд суртал, бид нарын энэ хууль чинь шүүхийн ил тод байдал, хүнд суртлыг бууруулах гэж байгаа, үйлчилгээг иргэнд ойртуулах гэж байгаа гээд байдаг. Гэтэл нэмээд нэг цахимаар үүссэн бичгийг нэг баахан цаасаар хэвлэдэг юм руу явчих вий дээ. Яг хууль хэрэглээд эхлэхээр их өөр ойлголт л доо. Тэгэхээр үүнийг юу гэж ойлгох юм бэ? Тэгээд ажлын хэсгээс бас нэг тайлбар сонсчхож болох уу?

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофонд хурдхан хариулаад, хэдүүлээ ажлаа хурдавчилмаар байна. 3 дугаар микрофон. 3 дугаар микрофон.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Баасанжав. Энэ шүүхийн цахимжуулалтын ажлын яг шүүхийн цахим платформын ажлын даалгавар боловсруулах, улмаар энэ гүйцэтгэгч компани, зөвлөх компанитай хамтран ажиллах асуудлыг хариуцаж байгаа юм.

Тэгэхээр яг санаа нь бол Учрал гишүүний хэлж байгаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүндрүүлэхгүй. Харин шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цаасан баримтыг 25 оны 01 сарын 01 хүртэл үүсчихсэн байгаа баримтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашидаа явна. Харин 25 оны 01 сарын 01-нээс эхлээд цахимаар баримтуудаа авч эхлэх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид тоон гарын үсгээ ашиглаад цахим баримт бичгээр өөрсдөөсөө гаргаж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг

гаргаж эхлэх ажлаа эхлүүлье гэж байгаа юм. Тэгэхээр болно гэдгээ бид нар бол үүгээр бүх ажиллагаа биш үе шаттайгаар бага үнийн дүнтэй хэрэг маргаан, таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэргүүдээс ингээд эхлээд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ингээд нээнэ гэж байгаа юм.

Цаасан болон цахим хэлбэртэй байна гэж байгаа нь хэргийн оролцогчдоос цаасан баримт ирж болно. Хэргийн оролцогчоос, мэргэжлийн этгээдээс биш. Тэгэх юм бол бид нар тэр цаасан баримтыг аваад, энэ хөрвүүлнэ гэсэн заалтаар захиргааны ажилтан хөрвүүлээд тоон гарын үсгээ зураад платформд оруулах юм. Тэгэхээр тэр цаасан баримтыг бол буцааж өгөхгүй. Тэр цаасан баримт шүүхийн, прокурорын, мөрдөн шалгах ажиллагааны юунд үлдэнэ. Тэгээд зарим нэг нууцад хамаарах зарим хэргүүд цаасан суурьтайгаа явна. Тэгэхээр 1 хэрэг 2 баримттай байна гэсэн санаагаар болно гэдгийг холбоогүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарим ажиллагаанууд цаасан суурьтайгаа 25 оноос эхлээд явж байхад ердийн иргэний хэрэг, ердийн эрүүгийн хэрэг бол цаасан суурьтайгаа явж байгаа явж байна гэдгээ тэр цаасан гэдгээр. Болон цахим гэдгээр бага үнийн дүнтэй зөрчлийн таслан сэргийлэх арга хэмжээний хэргүүд нь үүгээр явна гэж бид нар ойлгож байгаа. Уг нь санаа нь бол таны хэлж байгаагаар нэг хэргийг 2 баримт үйлдэх биш зарим хэргүүд цаасаар, зарим хэргүүд цахимаар. Уг нь бол үгчлээд хэлбэл зарим хэрэг нь цаасан суурьтай, зарим хэрэг нь цахим хэлбэртэй явж болно гэсэн уг нь санаагаар хэлж байгаа юм.

Тэгээд үүнийг бас амьдрал дээр бол нэг их тийм төөрөгдөхгүй байх үндэслэлээ шүүхийн цахим платформын шаардлагад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг нийцсэн байна гэж байгаа юм. Түүгээрээ платформ нь өөрөө танин

баталгаажуулаад тоон гарын үсэгтэй баримтыг зөвхөн аваад, тэгээд ирэхээр энэ баримт бичгийн хүчинтэй, үнэн зөв тэр логик бүртгүүлээгүй эсэх дээр бол маргаан үүсэхгүй. Тэгээд хөрвүүлчихсэн баримт бичиг бол өөрөө платформын шаардлагад нийцчих учраас платформ маань хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа өөрөө явцын дунд хөтлөөд явна.

Дээрээс нь ШЕЗ энэ цаасан болон цахим суурьтай гэдэг дээрээ хэргийн хөдөлгөөний аргачлалаараа яг таны хэлээд байгаа энэ хөөргөдлийг зохицуулчих боломжтой гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Хариулт авч дууслаа. Санал хураалт.

Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Миний техник ажиллагаагүй тул саналаа өгч чадсангүй. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд түрүүний томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор.

Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Сая санал хураалтад миний санал хураах төхөөрөмж маань гацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний томьёоллоор уншиж танилцуулсан томьёоллоор саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн санал хураалгасан нөгөө эхний юунд заалт дээр нэг ийм юу байна шүү. Нэг үг орхигдчихсон байгаа юм байна би түүнийг нь нэмээд уншаадахъя. Протоколд оруулчихъя. Энэ дээр бол санал хураагаад хэрэггүй. Энэ хэрэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх шийдвэр гаргах гэж гэсний дараа “нэмж” гэдэг үгийг оруулах юм. Тэгээд таслал 2 дахь хэсгийг хасах. Би тэгээд энэ “нэмж” гэдэг үгтэйгээ нийлүүлээд энэ сүүлийн өгүүлбэрийг уншихъя.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх шийдвэр гаргах гэж нэмж, 2 дахь хэсгийг хасах гэсэн ийм томьёоллоор оруулаарай. Энэ протоколд оруулж байгаа шүү.

3. Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх. Санал хураалт явуулъя.

Энэ чинь хэн яачхав? Алив ахиад энэ хэний санал. Учрал гишүүн юу? Саналыг хүчингүй болгоё. Учрал гишүүний микрофон өгье.

Н.Учрал: Сая миний санал орсонгүй ээ. Дахиж санал хураалгахыг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Энэ хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Үгүй, үгүй энэ

түрүүний юун дээр би энэ 2 дугаар хэсэг рүү орж ирэх байсан юм. Би үүнийг нь орхиод шууд уншаад танилцуулаад явчихсан байна лээ. Тэгэхээр би нэгэнт үүнийг хүчингүй болгочихсон юм чинь эхнээсээ энэ явчихъя.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй 1 саналтай байгаа тэр саналыг би уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “цахим хаягаар” гэснийг “цахимаар” гэж өөрчлөх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье 2 саналтай байгаа. 3 дугаар зүйл.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим

хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.” Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь хэсгийн “хаалттай” гэснийг “нээлттэй, эсхүл хаалттай” гэж өөрчлөх:

“1.Төрийн нууцад хамаарах хэрэг, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулна.”

“2.1.хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс хүсэлт гаргасан бол.” Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй 1 саналтай.

Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 2 дахь заалтын 34.4 дүгээр зүйлд 6 дахь хэсэг болгох:

“6.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан албаны нууцыг задруулахгүй байх баталгааны зохицуулалт шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахад хамаарахгүй.”. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байгаа.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Юу яахгүй ээ, одоо үнэхээр цаг байхгүй. Илүү тайлбар хэрэггүй. Гишүүд л асуулт асуувал асууна. Баярмаа шүүгч ээ, энд бол тэр хэзээ орж, та нарт зөндөө боломж юмнуудыг чинь өгөөд юу яасан. Одоо ажлын хэсэг энэ гишүүд л асуувал асууна түүнээс өөр энд бол санал оруулах юу байхгүй ээ, уучлаарай.

Тэгвэл Пүрэвдорж гишүүнээр энэ зарчмын зөрөөтэй санал гаргуулаад хийчих. Би 2 дугаар зүйлээс тэгвэл эхлээд санал хураалтаа явуулж байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

8.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

8.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

8.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

8.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

8.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг

үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.”

8.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.”. Санал хураалт.

Адьяаа дарга, Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Миний төхөөрөмж гацсан тул дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Д.Цогтбаатар: Санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний уншсан томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн алгасаад өнгөрсөн 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй санал гаргасан байгаа.

1 дүгээр зүйлийн талаар саналтай гишүүн Пүрэвдорж гишүүн тийм ээ. Пүрэвдорж гишүүн өөрөө унших уу бид нар унших юм уу? Та өөрөө унших. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гаргасан 1 дүгээр санал дээрх мөн зүйлийн гэсний

ард байгаа “2” гэснийг хасах гэдэг санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын уншиж танилцуулсан томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 1 дүгээр зүйлтэй холбогдолтой саналыг уншиж танилцуулъя.

1. Ажлын хэсгийн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 7.5, 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.5, 7.6, 7.7 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 5, 6, 7, 8 дахь заалт, 4 дэх заалтын 75^б дугаар зүйлийн 75^б.4.3, 75^б.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“7.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болох бөгөөд шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна. Цаасан баримт бичгийг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

7.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн мэдэгдэх хуудас, тэмдэглэл, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийг цахимаар хөтлөх, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, хуульд заасан бусад этгээдэд танилцуулах, гардуулах, эрх, үүрэг тайлбарлах, нэхэмжлэл, бие даасан шаардлага, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, нотлох баримтыг танилцуулах ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан цахимаар явуулж болно.

7.7.Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны

цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.”.

Ингээд санал хураалт явуулна. Одоохон түр хүлээж байгаарай. Санал хураалт саяын уншиж танилцуулсан томъёоллоор.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Энэ чинь 3 дугаар зүйл байгаа билүү. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн “нэрийг” гэснийг “гарчгийн” гэж, “өөрчлөн найруулсугай” гэснийг “өөрчилсүгэй” гэж өөрчлөх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Нэг санал байна.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 3 санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8.5 дахь хэсгийн “ажиллагаанд хөтлөгдөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10¹.1-10¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 10¹.1, 10¹.2 дахь хэсэг болгох:

“10¹.1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь шүүхийн цахим платформын шаардлагад нийцсэн байна.

10¹.2. Цаасан баримтыг шүүхийн захиргааны эрх бүхий ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.”. Санал хураалт.

Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Миний төхөөрөмж гагцхилаа. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Сая бас энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, Дээд шүүхийн асуудлуудыг бид бас энд ярилцах ёстой гэж бодож байгаа. Тэгээд сая Дээд шүүхийн саналыг бас хураалгасан учраас Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг зарчмын зөрөөтэй саналаар хураалгаж өгөх ийм санал оруулж байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье. Шүүхийн ерөнхий зөвлөл аль асуудлын аль хаана байгаа санал вэ? Тэрийгээ өгөөдөх дөө.

Н.Баярмаа: 72.1.6 дээр Шүүгч гэдгийг хасах гэсэн саналтай 5 дугаар зүйл дээр явж байсан юм. Тэгээд ажлын хэсэг дээр энэ томъёоллоор оруулж ирээд Байнгын хороон дээр хэрвээ дэмжигдэхгүй бол хасагдах саналтай. Хуучин хуулийнхаа хэвээрээ явахаар тийм саналтай байгаад байгаа юм. 72.1.6 дээр. Тийм. Яагаад гэхээр энэ 72 өөрөө нөгөө Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүний нөөцтэй холбоотой. Тийм.

Д.Цогтбаатар: Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг уншъя. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Энэ дээр санал хураалгаж өгөөрэй.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, үгүй. Та нар ингээд би бол та нарын ярьж байгаа, хэлж байгааг бүгдийг нь сонсож аль болох нэгтгэж оруулж байна шүү, бас ингэхгүй шүү. Шүүхэд бид нар хүндэтгэлтэй ханддагтай адилхан хууль тогтоох байгууллагад та нар хүндэтгэлтэй хандана шүү. Би ингээд зөөлөн хандаад аль болох юунуудыг чинь сонсоод байх тусам орж ирээд эндээ ингээд нэгтгээд ороод ирчихсэнийхээ дараа асуудлууд гаргаад байна.

Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье. 2 дугаар микрофон.

Д.Мөнхтуяа: Баярлалаа. Уул нь энэ асуудлыг өмнөх Байнгын хорооны хурал дээр яриад, тэгээд ингээд санал зөрөлдөөд, ажлын хэсэг дээр яриад нэгдсэн саналаар орж ир ээ гээд. Тэгээд Сандаг-Очир гишүүн ороод ажлын хэсэг дээр яриад, өргөн барьсан төсөл нь зөв юм байна. Түүгээрээ явъя гээд эцэслээд шийдчихсэн юм.

Тэгээд сая гэнэтхэн Адьшаа гишүүн зарчмын зөрөөтэй санал гэж байна л даа. Энэ ямар агуулга байгаа вэ гэхээр 2021 оны Шүүхийн тухай хуулиар шүүхийн шүүгчийн сургалтыг бүхэлд нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн гэдэг тусад нь байгууллага байгуулаад ингээд шүүгчийн бүх сургалтыг нэгдсэн бодлогоор хүрээлэнгээр явуулъя гээд 21 оны шүүхийн тухай хуулиар ингээд бүр тусад нь ингээд заачихсан.

Тэгээд түүн дээр 72.1.6 дээр хуучин ерөнхий зөвлөл шүүгчийн сургалт явуулдаг байсан заалт дээр шүүгчийн сургалтыг бас ерөнхий зөвлөл явахаар юм шиг ийм давхардсан заалт байгаад байгаа байхгүй юу. Хүчинтэй хэвээрээ. Тэгээд гадаад, дотоодын байгууллагууд сургалтын юмтай нэг цонхоор харах гэхээр ерөнхий зөвлөл нь ч сургалт явуулдаг юм шиг, хүрээлэн нь ч сургалт явуулдаг юм шиг ингээд манайх сургана, манайх сургана гээд. Тэгээд бид нар нэг

талдаа нэгэнт Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэн бие дааж байхад Шүүхийн ерөнхий зөвлөлийн 72.1.6 дээр байгаа шүүгчийг сургана гэдэг заалтыг авъя гэсэн юм. Тэгэхгүй бол энэ хууль чинь давхцаад байгаа юм. Тийм агуулгатай юм. Тэгээд бид нар шүүгч гэдэг шүүгчийг ерөнхий зөвлөлөөс шүүгчид зориулсан сургалт явуулах агуулгыг нь хасаад, угаасаа Шүүхийн сургалт судалгааны хүрээлэнг байгуулчихсан асар их төсөв өгч байна. Бүх шүүгч нарын сургалт энэ дээр сургалтын хөтөлбөрийн бодлогын хороогоороо зангидагдаад явж байна.

Тэгээд ингээд 2 газар ийм юм байхаар ойлгомжгүй болоод байгаа юм. Тэгээд үүнийг зүгээр хуулийнхаа юунд нэгтгээ гэдгээр хууль санаачлагч нь дэмжээд, ЗГ дэмжээд, ажлын хэсэг дээр нэгдмэл саналтай орж ирж байгаа асуудал байхгүй юу. Тэгээд үүнийг энэ юу төслөөр нь хэвээр үлдээж өгөөч. Шүүгч гэдгээ хасаж нэг талдаа гаргаж өгөөч. Тэгэхгүй бол тэгээд хаана нь ч сургалт явуулж болохоор юм шиг шүүхийн хуулийнхаа заалтыг Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийнхээ чиг үүргийг үгүйсгээд байгаа байхгүй юу. Одоо ингээд гадаад сургалтууд, олон улсын байгууллагуудтай, шүүхийн академиуд, шүүхийн хүрээлэнгүүд хамтран ажиллах гэрээ хийх гэхээр хаана нь шүүхийн сургалтаа хариуцаад байгаа нь ойлгомжгүй.

Тэгээд шүүхийн академи болох гээд энэ хуульд орчихсон явж байна. Тэгээд шүүхийн академи болчихоод шүүхийн бүх сургалтаа авъя гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл дахиад давхар сургана гэдэг ийм юм оруулж ирээд, төсөв, хөрөнгө чинь хуваагдана. Байгаа жоохон хүний нөөц сургах тэр бүх бодлого чинь 2 тийшээ салаад хуваагдлаа.

Тэгэхээр энийгээ энэ төслөөр нь хэвээр үлдээж өгөөч гэж ингэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Адьшаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяа: Мөнхбаатар гишүүн надад ийм санал ирүүлсэн юм. Тэгэхээр энэ Дээд шүүх сая та нар саналаа орууллаа шүү дээ. Энэ жоохон зарчимтай бай, Дээд шүүхийнхэн. Энэ Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдэл энд байна. Та нар тэр шүүх эрх мэдлээ тэндээ хэрэгжүүл. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн бүтцийн байгууллага Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо өнөөдөр бүх боловсон хүчин сургалт судалгааны асуудлыг хариуцна гээд ингээд энэ Шүүхийн тухай хууль дээр чинь байж байгаа шүү дээ. Тэгээд энэ нь яагаад ингэж байдаг юм та нар. Эндээс ингээд энэ улсын их бид аль болох л үүнийг чинь шийдээд өгье гэж байна шүү дээ.

Тэгээд сая Баярмаа шүүгч ингээд Пүрэвдоржид хэлээд ингээд дэгээ алдагдуулаад явууллаа шүү дээ. Тэгээд адилхан энд хүндэтгэлтэй хандъя гээд л ингээд ингэж байхад чинь та нар яахаараа ингэж эсэргүүцэж үг хэлж байдаг юм. Ийм эрх байдаг юм уу? Өнөөдөр чи. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд ч ийм юм алга. Тэгэхээр үүнийг би санал хураалгая. Мөнхбаатар гишүүн надад сая мессеж ирүүлсэн юм. Тэгээд ингэчихлээ, би ажилтай болоод явчихлаа, үүнийг ийм ойлголцол байна шүү гэдэг зарчмын үүдэн дээр л би зарчмын зөрөөтэй санал оруулж байгаа юм. Тэгээд би тэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаас асуусан юм. Энэ ямар учиртай юм бэ? Мөнхбаатар гишүүн ингээд байна гэж би ярьсан юм. Түүнээс биш би тэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын саналаар би оруулаагүй шүү. Энэ бол миний энэ чуулганы дэгийн тухай хуульд оруулах миний бүрэн эрхийн асуудал шүү.

Д.Цогтбаатар: Ингэе, одоо болсон. Болсон, тийм юм байхгүй, ингэе. Гишүүд, би энэ дээр тайлбар хэлэхгүй. Гишүүд өөрийнхөө итгэл үнэмшилээр

саналаа өг. Тийм учраас санал хураалт. Яг энэ сая зарчмын зөрөөтэй уншиж танилцуулсан саналаар нь санал хураалт явуулъя. Гишүүд итгэл үнэмшилээрээ саналаа өг.

Санал дэмжигдсэнгүй. Гэхдээ Адьяа гишүүний бас зөв шүү. Энд байна шүү дээ. Адьяа гишүүн бол энэ Их Хурал дээр өөрийнхөө эрхийг эдэлж байгаа. Тийм учраас би өгч тэр түрүүн өнгөрчихсөн асуудлыг буцаагаад сөхөж оруулж ирсэн ч би үг өгөөд саналыг нь хураалгалаа шүү. Тэгээд би энэ дээр ямар нэгэн байр суурь хэлэлгүй гишүүдийг итгэл үнэмшилээр нь ямар нэгэн чиглүүлэлгүйгээр өөрсдөө өглөө шүү.

Тэгээд асуудлаа үргэлжлүүлээд явуулъя. Санал хураалтаа цаашаа үргэлжлүүлье.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 32.9, 32.10, 32.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32.9 дэх хэсэг болгох, мөн зүйлийн 4, 5, 6 дахь заалтыг тус тус хасах:

“32.9.Шүүх цахим баримт бичгийг эргэлзээтэй гэж үзвэл энэ хуульд заасны дагуу шаардлагатай ажиллагаа хийнэ.” Санал хураалт. Саналаа өгцгөөгөөрэй, саналаа өгөөрэй.

Адьяа гишүүн саналаа өгөх үү. Одоо ер нь дууслаа. Тэгээд танай Засгийн газрын хууль өшөө орж ирэх гэж байна.

Адьяа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяа: Миний төхөөрөмж гацсан учраас дахиж санал хураалгаж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ чинь ажиллахгүй байна шүү дээ. Ганбат гишүүн микрофоноо өгөх үү, Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Би бол саналаа дэмжиж өгсөн юм сан, нэр нөгөө талд гараад байна. Ахиж санал хураалгаж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

58,3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан томъёоллоороо санал хураалт явуулъя.

53,5 хувиар санал дэмжигдлээ.

Би түрүүн ингээд хэлэлцүүлгийн дундуур өөрсдөө асуудал оруулж ирээд, энэ хууль чинь уншиж танилцуулахад бас хэцүү болж байна шүү. Түрүүн нэг юуг орхиод уншичихаж.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 10¹ дүгээр зүйлийн 10^{1.6} дахь хэсгийн “үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем” гэснийг “эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн үүсгэсэн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар,” гэж өөрчилж, 10^{1.5}, 10^{1.7}, 10^{1.8} дахь хэсгийг хасах. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн “гардуулна.” гэсний дараа “Цахим нэхэмжлэлийг хариуцагчид энэ хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1}-д заасны дагуу гардуулна.” гэж, 57.2 дахь хэсгийн “ирүүлнэ.” гэсний дараа “Цахимаар гаргасан хариу тайлбарыг тоон гарын үсгээр баталгаажуулна.” гэж, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “үүрэгтэй” гэсний дараа “Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхээс цахим системээр мэдэгдэл илгээснээр товыг мэдэгдсэнд тооцно” гэж,” гэснийг, “108.4 дэх хэсгийн “гардан авна.” гэсний дараа “Цахимаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1}-д заасны дагуу гардуулна” гэж,” гэснийг тус тус хасах. Санал хураалт.

Энэ Ганбат гишүүн микрофоноо авах уу? Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Минийх бас л болохгүй байна шүү дээ. Би ер нь төхөөрөмжөө сольдог юм уу.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье. Үгүй, үгүй, та ахиад хэлчих.

Д.Ганбат: Би төхөөрөмжөө сольчихлоо, одоо гайгүй ажиллах байлгүй дээ. Би дэмжиж санал өгөөд байгаа юм, тийм.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Энэ чинь сая 2 дугаар зүйл байсан тийм ээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/“9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг нээлттэй явуулах

9.1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

9.2.Хэргийг шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулахаар, эсхүл хэрэгт авагдсан нотлох баримтыг олон нийтэд мэдээлэхгүй талаар шийдвэр гаргаж болно.

9.2.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй гэрч, хохирогч оролцож байгаа бол шүүх өөрийн санаачилгаар;

9.2.2.нээлттэй ил тод байх нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулж болзошгүй талаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлт тайлбарыг шүүх үндэслэлтэй гэж үзсэн;

9.2.3.цаашид үргэлжлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй гэж үзвэл.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэлбэртэй байна. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч гомдол, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сонирхогч бусад этгээд хүсэлт гаргах эрхтэй.

9.4.Энэ хуулийн 9.2-т заасны дагуу шийдвэрлэсэн хэргийн үйл баримт, нотлох баримтын талаар олж мэдсэн хэргийн оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, бусад этгээд уг үйл баримт, нотлох баримтын талаар олон нийтэд түгээх, хэвлэн нийтлэх, аливаа байдлаар нийтэд дэлгэхийг хориглоно.

9.5.Иргэний эрх зүйн чадамжгүй, согтуурсан, мансуурсан, 18 насанд хүрээгүй хэргийн оролцогч биш этгээдээс бусад хүн нээлттэй шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах зорилгоор шүүх хуралдааны танхимд чөлөөтэй нэвтрэн орох эрхтэй. Шүүх хуралдаан хөндлөнгөөс ажиглагч этгээд нь шүүх хуралдаанд оролцох дэг, журмыг баримтална.”. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ганбат гишүүн үү? Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ер нь бол энэ шүүх засаглалыг хараат бус байх энэ зүйл заалт дээр энд өнөөдөр сууж байгаа хэдэн гишүүн л, бараг АН-ын л хэдэн гишүүд. Тэгээд 1, 2, 3 сайд л сууж байх шив дээ. Мөнхцэцэг гишүүн байх юм. Энэ бусад нь хаачаад байдаг юм бэ? Нөгөө амаараа л янз бүрийн юм яриад байдаг улсууд. 1.

2-т нь, одоо юу байна аа. Энэ төрийн нууц, хэрэг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны нээлттэй болно гээд түрүүн

зүйл, заалт уншаад өөрчлөөд байна л даа. Үгүй ээ, тэр нэг 4 цагдаа төр нь хамгаалах ёстой, өөрийгөө хамгаалах чадваргүй тийм насанд хүрээгүй хүүхдүүдийг хүчирхийлсэн мэдээлэл нь тэд нар дээр байдаг. Ийм юмыг энэ дээр бол насанд хүрээгүй хүүхдийг нь ил гаргахгүй байж болж байна. Тэр 4 нөхрийг нь ил гаргаж болох уу? Тийм маягаар тэр нээлттэй хийх гэдгээ боломжтой юу?

Нөгөө тал нь бол Эрдэнэс Тавантолгойг бол оффтек гэрээ гээд хэд хэдэн 9 гэрээ бил үү. Төрийн нууцад хамааруулаад авчихсан байсан. Хэзээ нэгэн цагт түүний шүүх хурал нь болж байгаа юу, болохгүй байгаа юу? Энэ юм чинь тэгээд ил тод байх юм уу эсвэл аж ахуйн гэрээ юм уу, юу юм? Уул нь бол тэр бол аж ахуйн гэрээ л гэж бодож байна. Хэн ч нууц биш. Энэ 2 юман дээр надад нэг хариулаад өгөөч. Энэ чинь хэн дуртай нь гарч ирээд л ийм шийдвэр гарчихлаа, ингэчихлээ, авлигатай тэмцээд байна аа, шүүхийг харъя, шүүх яахыг нь харъя гээд л ингэчихдэг. Тэгээд нөгөө шүүх нь болохоор бүгдийг нь 40 саяар торгоод л явуулчихдаг. Ийм л замбараагүй юм болоод байна шүү дээ. Хэзээ энэ шударга үгүй ээ, энэ шударга нь дээр биз дээ нөхөд өө. Хэзээ шударга байх юм бэ, энэ шүүх чинь. Энэ цагдаа, хүчний байгууллага чинь. Ард түмэн бид нар юунд итгэх юм бэ. Хэнд итгэх юм бэ? Өнөөдөр шүүхийн хуулийг сайжруулаад баталж л байна гэнэ. Энэ дотор чинь янз бүрийн юмнууд их байна шүү, бас. Ингээд харж байхад.

Тэгээд Засгийн газар нь дэмжсэн л гэнэ, тэр нь дэмжсэн л гэх юм. Сонин сонин зүйл заалтууд нэлээн байна. Би үүнийг сонсьё гэж бодож байна, ер нь.

Д.Цогтбаатар: Хууль санаачлагчийн хувьд би хариулчихъя. Тэгээд ажлын хэсгээс энэ дээр гүйцээгээд хариулах байх. Яг Ганбат гишүүн ээ, таны хэлж байгаа зөв. Саяын одоо, жишээлбэл энэ хуулийг санаачилж

оруулж ирж байгаагийн шалтгаан нь жишээлбэл нүүрсний хэрэг дээр улс даяараа бүгдээрээ мэдээд байхад шүүх хуралдаан хаалттай яваад байна шүү дээ. Түүнийг хаах ямар ч угаасаа шаардлагагүй. Яагаад гэвэл бүгдээрээ дотор юу болж байгаа, ямар асуудал хэлэлцэгдэж байгааг мэдээд байна шүү дээ.

Тэгэхээр ингээд процессын хуульдаа төрөл бүрийн заалтууд оруулж ирээд яг газар дээрээ нэг яамны нэг зүгээр газрын дэд дарга бараг нууц гээд тэмдэглэл үйлдээд л хийчихсэн байхад тэр бичиг баримтууд нь нууц болоод шүүх хуралдаан нь хаагдах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр тийм юмыг ерөөсөө байлгахгүй. Шүүх угаасаа хуулийн зарчим чинь шүүх нээлттэй байх зарчимтай улс шүү дээ, манайх.

Тэгэхээр ерөөсөө үүнийг аль болох максимум нээлттэй байлгах. Тийм учраас хаалттай байх юм нь бол зөвхөн тагнуулын тусгай нууц ажиллагаатай ч юм уу эс үгүй бол мөрдөн байцаах нууц ажиллагаатай ч юм уу яг зайлшгүй хаагдах ёстой төрийн нууцад хамрагдах асуудлаас бусад юмыг бол шууд нээлттэй болгож өгч байгаа юм. Одоо энэ харин тийм учраас тэр жишээлбэл нүүрсний хэрэг эд нар бол эсрэгээрээ бүр нээлттэй болж байгаа байхгүй юу.

Харин энэ өсвөр насны хүүхэд, энэ хувийн нууц эд нартай холбоотой асуудлууд дээр бол миний ойлгож байгаагаар бол хэсэгчлэн энэ дээр тэр зооохон хүүхдүүдийн асуудал хэлэлцэгдэхгүй. Энэ нууц болохоос биш бусад нь таны хэлж байгаа тэр 4 цагдаа бол нээлттэй л тэр шүүх хуралдаан явагдах боломжтой.

Тэгээд энэ дээр бас ажлын хэсэг 1 дүгээр микрофоныг өгье. Гүйцээгээд хариулчих уу.

Б.Батцэрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн ил тод,

нээлттэй байдлыг хангах хүрээнд бол шийдвэр үйл ажиллагаа бол нээлттэй байх ёстой. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар төрийн нууц, албаны нууц, хувийн нууц гэдэг нэрийн доор эдгээр хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хаалттай явагдах, тэгээд шүүхийн шийдвэрийг хардах ийм үндэслэлүүд бол бий болоод байгаа юм.

Тийм учраас Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас одоо байгаа нөхцөл байдлыг илүү сайжруулъя, нээлттэй ил тод байлгая гэдэг хүрээнд тодорхой саналуудыг хууль санаачлагчид хүргүүлсэн. Ингээд Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөл бол төрийн нууцад хамаарах хэрэг. Тэгэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй болгоё гэж ийм томъёолол орж ирсэн байгаа. Энд бол ажлын дэд хэсэг бол санал нэгтэй байгаа.

Дээр нь энэ хуульд угаасаа тусгайлан 3 төрлийн тохиолдолд хуралдааныг хэлэлцүүлгийг хаалттай явуулахаар заачихсан байдаг. Түүний нэг нь бол хүүхдийн хэргийг хаалттай явуулна. Гэхдээ хүүхдийн ашиг сонирхлын үүднээс тэр хэргийг нээлттэй явуулах нь ашигтай гэж үзэх юм бол хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр хуралдааныг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нээлттэй явуулах эсэх асуудлыг шүүх шийдвэрлэхээр ингэж орж ирж байгаа.

Дээр нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль бий. Тэгэхээр энэ хамгаалалтын арга хэмжээ авсан тэр гэрч, хохирогчийн нэрийг нууцлах, хамгаалах тэр хүрээнд бас хэлэлцүүлэх хуралдаанууд бол хаалттай явуулах шаардлага үүсдэг.

3 дахь нь бол тэр мөрдөн шалгах нууц ажиллагаа, хамтран ажиллах гэрчээ тогтоохтой холбоотой. Тэр хэлэлцүүлгүүд хаалттай явагдана.

Үүнийг энэ хуульд хуульчлан заасан байдаг.

Тийм учраас төрийн нууцад хамаарах хэрэг гэдэг дээр нэмээд энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахаар ийм томъёолол бол хийгдсэн байгаа юм.

Тэгээд цаана нь хохирогчийн бас аюулгүй байдлыг хамгаалах, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах. Өөрөөр хэлбэл урьдчилан гэрч, хохирогчийн хамаа аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн дагуу шийдвэр гаргаагүй боловч тухайн шүүх хуралдаан дээр орж ирээд хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөхөд миний эрсдэл учрах гээд байна.

Тэгэхээр энэ хэлэлцүүлгийг хаалттай явуулж өгнө үү гэсэн хүсэлт гаргах юм бол үүнийг шүүх бас хэлэлцээд хаалттай эсвэл нээлттэй явуулах эсэхийг шүүх шийдвэрлэхээр энэ 2 дахь заалт нь орж ирж байгаа юм.

Бусад бүх шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанууд бол нээлттэй явагдана. Түүний дотор авлигын гэмт хэргүүд мөн багтаж байгаа юм.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүн микрофоныг өгье. Асуултаа ахиад давтъя.

Д.Ганбат: Асуултаа ахиад давтъя. Тэр хүчирхийлэл үйлдсэн, төрд байх мэдээллийг ашигладаг, тухайлбал би тэр 4 цагдаа танай шүүх хурал дээр очих л байлгүй дээ. Хэзээ нэгэн цагт. Тэр 4 ил гарах уу, харуулах уу, харуулахгүй юу. Би тэр насанд хүрээгүй хүүхдийг бол хэзээ ч ил гаргаж харуулж болохгүй гэж бодож байна. Энэ хуульд байна л даа. Хэсэгчлээд нөгөө 4-ийг бол харуулах ёстой л гэж бодоод байна.

Яагаад вэ гэхээр энэ чинь тэр фидофил гэдэг үүнийг дахин давтан хийдэг ийм хүмүүс чинь. Ийм хүмүүсийг

бүр ил зарладаг. Энэ дотор ингээд ойрхон явж байна уу гээд бүр мэдээлэл нь ил гарч ирдэг, сүлжээн дотор тийм болчхоод байгаа шүү дээ.

Нөгөөдөх нь төрийн нууц гэж байгаа. Тэр гэдгээ та нар юу гэж ойлгож байна. Би бол Монгол Улсын төрийг энэ Улсын Их Хурал гэж бодож байна. Энэ 76 гишүүн гэж бодож байна. Ард түмнийг төлөөлж байгаа. Удахгүй 126 гишүүн болох байх.

Д.Цогтбаатар: Микрофоныг гүйцээгээд өгье.

Д.Ганбат: Тэгээд тэр оффтек гэрээг харсан л даа. Маш нууц гээд л тамга дарчхаж байна. Түүнийг хэн дараад байдаг юм. Засгийн газар нь дардаг юм уу тийм тамгатай бүх юм төрийн нууц болох уу. Яг ямар учиртай, юу гэж ойлгох вэ?

Тэгээд энэ шүүгч нар байна. Улсын дээд шүүх. Энэ Улсын дээд шүүхийн 24 шүүгчийг бүгдийг нь зурагтай нь гаргаж ирээд түүний бараг 70, 80, 90 хувь нь байх даа. Улсын Их Хурлын гишүүн асан, нэг намын дарга бол тэр нь ингэж хулгай хийж байсан, тэр нь ингэж луйвардаж байсан, тэр нь тэрний үед томилогдож байсан гээд ингээд нэр заагаад хэлж байсан. Одоо ч гэсэн бичлэг нь сошиалд байгаа байх. Тэгээд ийм улсуудаар бид нар шүүх толгойлуулж байгаа нь гэж ойлгодог. Үнэн юм уу худлаа юм уу тэр чинь. Тийм шүүхээр шүүлгээж байна гэхэд бид нар шударга байна. Ийм байна гэж ойлгож болох юм уу? Шударга л байя л даа гэж яриад байсан. Шударга нь дээр биз дээ. Ер нь яг ямар учиртай юм бэ, тэр чинь.

Одоо Улсын дээд шүүхийн шүүгч нэг тэр болгон асуугаад байх боломж олддоггүй. Нэгэнт бид нар хууль ярьж байгаа, хууль тогтоох гэж байгаа учир энд та бүхэн ажлын хэсэг болоод ороод ирчихсэн байна. Тэрийгээ нэг хэлээдэх дээ.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулах уу. Тэр 4 цагдаа жишээлбэл нээрээ ороод ирвэл ил болох уу, үгүй юу гэдэг. 1 дүгээр микрофон.

Б.Батцэрэн: Ганбат гишүүний асуултад гүйцээж хариулъя. Тэгэхээр энэ ЭХХШТХ-д энэ шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах журамтай холбогдуулаад энэ асуудал бол хохирогчид хамааралтай, гэрчид хамааралтай, насанд хүрээгүй шүүгдэгчид хамааралтайгаар ингэж орж ирж байгаа юм.

Насанд хүрээгүй хүний хэргийг хянан шийдвэрлэх тусгай бүлэг дээр хаалттай явуулна гээд заачихсан. Энэ нь бол тэр насанд хүрсэн шүүгдэгч нар, тухайлбал тэр төрийн тусгай албан хаагч нарт бол хамааралгүй гэж ойлгоно. Тухайлбал энэ хэргийн хохирогч насанд хүрээгүй хүүхэд мэдүүлэг өгөхдөө энэ хэсгийг нь хаалттай явуулж өгөөч ээ гэсэн хүсэлт гаргавал шүүх хэлэлцээд хаалттай явуулж болно. Энэ бол шүүхийн, шүүх бүрэлдэхүүний шийдвэрлэх эрх хэмжээнд байгаа юм. Түүнээс биш таны хэлснээр тэр хүүхдийн хэргийг хохирогч хүүхдийн хүсэлтээр энэ хэргийг хаалттай явуулна гэдэг нь тэр шүүгдэгчийн тэр мэдүүлэг авах, өгөх хэргийг шинжлэх ажиллагааг хаалттай явуулна гэсэн үг биш.

Урьд нь бол төрийн нууц, байгууллагын нууцад хамаарах ийм баримт мэдээлэл орсонд бол шүүх хуралдаан бүхэлдээ хаалттай явагддаг. Энэ нь өөрөө Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдсан байсан.

Тийм учраас энэ шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21.6-д заасан тэр төрийн биш ээ, албаны нууцыг задруулахгүй байх тэр үүрэг бол энэ шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй гэсэн ийм нэмэлт,

өөрчлөлтийн томъёолол бол сая хэлэлцэгдээд батлагдаж байгаа юм. Юу, дэмжигдэж байгаа юм.

2 дахь асуулт нь бол Улсын дээд шүүхийн шүүгч нарын талаар тодорхой нэр зааж шүүмжилсэн тухай та асууж байх шиг байна. Тэгэхээр яг тодорхой ямар хэрэгт буруутгах буруутай гэж үзэж байгаа бол? Үүнийг бол үндэслэлтэй тавих ёстой гэж бодож байна. Тэгээд шүүх эрх мэдлийн дээд байгууллага шүүхийн нэр бүхий шүүгч нарыг буруутгах гэж байгаа бол үүнийг бол үндэслэлтэй тавих ёстой. Тэгээд ийм соёл бол бас хууль тогтоох байгууллагад ч гэсэн байх ёстой гэж би үздэг.

Тийм болохоор хэрвээ асуудал байгаа бол үүнийг холбогдох байгууллагад, сахилгын хороонд, АТГ-т тавьж шалгах ийм боломж бол бий. Үндэслэлгүйгээр яг ямар асуудал буруутгаад байгааг бол би сайн мэдэхгүй байгаа учраас хариулах боломжгүй байна.

Д.Цогтбаатар: Мөнхтуяа гишүүн 2 дугаар микрофон.

Д.Мөнхтуяа: Ганбат гишүүний асуултад хариулъя. тэр Улсын дээд шүүхийн шүүгч нартай холбоотой асуудал ярьж байна. Тийм ээ, энэ бол тэр Улсын Их Хурлын гишүүн байсан, Засгийн газрын гишүүн байсан, улс төрч өөрийн цахим хуудсаараа дамжуулаад Улсын дээд шүүхийн шүүгч нар бүгдээрээ гэмт хэрэгтнүүд, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүмүүс байна энэ тэр гэж тийм мэдээллийг бол тараасан. Үүнтэй холбоотой ер нь бол Шүүхийн тухай хуулиар шүүгч нарын эрх зүйн байдалд яг таны энэ асууж байгаа асуудал дээр бид нарт ерөөсөө ямар ч буцаагаад хэвлэлийн хурал хийгээд ингээд хариу өгөх ямар ч тийм эрх зүйн боломж байдаггүй. Тэр битгий хэл ер нь болохгүй гээд ингээд заачихсан шүүхийн хуулиар. Шүүгч бол ямар нэг байдлаар мэдэгдэл хийдэг ийм

үйл ажиллагаа ерөөсөө явуулж болохгүй гээд.

Тэгээд хэн ч юу ч хэлж чадахгүй болохоор зэрэг ер нь бол шүүгч нарын талаар үндэслэлгүй мэдээллийг улс төрийн зорилгоор эсвэл нэг улс төрч нөгөө улс төрчөө намнах зорилгоор байнга гаргаж байдаг. Тэгээд энэ бол ерөөсөө нууц биш. Одоо ингээд л шүүгч нарыг авлигад автсан, тэр ч улс төрчийн хүн, энэ ч хүн гээд л ингээд байнга ярьж байгаа юм. Бид тэгвэл шүүхийн хуульд хууль тогтоох байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд бид нарыг энэ хариу арга хэмжээ авах боломжийг олгож өгөөч. Хэлж чадахгүй, юу хэлэх юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгч нар албан ёсоор хандсан. Улсын дээд шүүхийн шүүгч нар. Ийм асуудал яриад байна. Үүнийг эцэслэж өгөөч. Яагаад гэвэл Үндсэн хуулиар энэ шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөл.

Тэгэхээр Ганбат гишүүний энэ асуулт бол үндсэндээ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуух ёстой. Энэ ерөнхий зөвлөлийн дарга энд сууж байна. Бид нар хандсан. Энэ нэг улс төрч хүн ингээд олон нийтийн цахим сүлжээгээр ийм юм тараагаад байх юм. Тэр АТГ-аас албан ёсны хариуг нь аваад хэн гэдэг шүүгч дээр ямар асуудлаар хэрэг үүсчихсэн байгаа юм уу, яаж байгаа юм, тэр юмыг нь авч өгөөч ээ гээд. Ингээд албан ёсоор хүсэлт гаргасан.

Дээр нь энэ хүнтэйгээ тэр баримт мэдээлэл юу байдаг юм энэ гомдол гаргадаг юм уу энэ хүнийхээ учрыг олж өгөөч. Энэ тоглоом биш. Улсын дээд шүүх гэдэг бол шүүхийн дээд байгууллага. Тэгээд дээд байгууллагын хэдэн шүүгч нарыг бүгдийг нь ингэж онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн мэтээр олон нийтэд цацдаг. Тэр мэдээллийг нь тэр дороо 10 мянга, 20 мянган хүн ингээд

лайв үзээд сууж байдаг юм байна лээ. Тэгээд энэ дээр энэ хууль зүйн үр нөлөөтэй хамгаалалт авах ямар ч тийм боломжийг бол шүүхийн хуулиар бид нарт олгоогүй шүү.

Харин Шүүхийн ерөнхий зөвлөл энэ асуудлаар холбогдох байгууллагад нь хандах, шалгуулах, үнэн мөнийг нь тогтоолгох чиг үүрэг нь байдаг. Тэгээд түүнийхээ дагуу миний ойлгож байснаар бол тэр бид нар бас дараа нь асуусан АТГ, цагдаад хандаад тэндээс шүүгчтэй холбоотой ямар нэг ийм асуудал байхгүй байна эд нар гэсэн бичиг сачиг ирсэн юм шиг байна лээ. Бид бол ямар ч боломж байдаггүй. Одоо таны хэлснээр гараад хэлье гэхээр ингээд эрх зүйн байдал нь ийм хязгаарлагдмал, гар, хөл, ам бүгд хүлээтэй. Асуусан учраас хариулж байна.

Ганц энэ хүний асуудал биш. Өдөр тутамд ийм дайралт доор байж байгаа бид нар. Хийсэн хэрэг байхгүй. Ажил албан тушаалаа үнэнч чин шударгаар тангаргийнхаа дагуу хийгээд сууж байгаа хэдэн шүүгч нар байна. Болдоггүй хүмүүс байдаг байж магадгүй тэд нар нь Шүүхийн сахилгын хороогоороо энэ хуульд заасан журмынхаа дагуу үнэхээр зөрчил дутагдал нь тодроод, тодорхой болдог юм бол сахилгын шийтгэлээ аваад энэ албан тушаалаас зайлуулж баймаар байна. Ер нь бол.

Тэгээд ингээд шүүх рүү ингээд дайрдаг. Одоо бид нараас ингээд хариулт нэхээд та нар яагаад хариулдаггүй юм гээд. Бид юу хариулах юм. Хуулиар тийм боломж байхгүй. Үнэхээр Их Хурал дээр өнөөдөр ирээд энэ асуусан учраас хариулах харин боломж олдлоо. Тэгээд энэ Ерөнхий Зөвлөл энэ дээр ямар арга хэмжээ авах ёстой юм. Ер нь яах ёстой юм. Тэгээд энэ энгийн иргэд дайрахаасаа илүү дандаа эрх мэдэлтэй улс төрчид, эрх мэдэлтэй албан тушаалтнууд дандаа энэ төрийн толгойд гараад суучихсан хүмүүс л ийм юм ярьж байгаа шүү дээ. Тэгээд яах юм. Энэ хүмүүстэй бид нар ер

нь яах ёстой юм. Эсвэл арга замыг нь хуулиар тогтоож өгөөч.

Д.Цогтбаатар: Энэ дээр ингэнэ ээ. Ганбат гишүүний асууж байгаа асуулт Ганбат гишүүн асуугаад байгаа биш. Олон нийт ийм ойлголттой байгаа байхгүй юу. Тэгээд тэнд тэр хүн ингээд ярьчихсаны дараа олон нийт бүр л ийм ойлголттой. Асууж байгаа нь л Ганбат гишүүн болохоос биш олон хүмүүс ийм асуулттай байгаа. Яг би үүнийг хэлэх гэж байгаа юм. Сая Мөнхтуяа гишүүн ээ, ингэж асууснаараа та нарт харин өшөө Мөнхтуяа шүүгч ээ, ингэж асууснаараа та нарт хариулах боломж гаргаж өгч байгаа байхгүй юу. Их Хурал дээр та нар орж ирээд ингэж өөр газар та нар нээрээ хүнтэй ч уулзаж чадахгүй болчихсон.

Тэгээд 1 хүний амыг юу таглаж байгаад л, дураараа хэлж болдог ийм байгууллага болгочихсон байж байгаа. Тэгэхээр энд энэ асуултыг ашиглаад та нар үүнийгээ хариулах ёстой, 1.

2-т, харин би нэг ийм юм хэлчихье. Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн энд байж байгаа дээр Ганбат гишүүний энэ асууж байгаа асуултын хариултыг яг тэр тэгвэл хэдүүлээ асуудлыг ингээд тавья. Тодорхой хүмүүсийн нэр заагаад улс төрч юм ярьчихсан байж байна шүү дээ. Түүн дээр ямар арга хэмжээ авсан юм бэ, ямар шалгалт явуулсан юм бэ. Энэ хариултыг Ганбат гишүүнд асууж байгаа хүнд нь та нар албан ёсоор өгөх хэрэгтэй байна. Түүнийг одоо энд бид нар хуулиа явуулъя. Яагаад гэвэл энэ гишүүд чинь энд байж байгаа дээр бид нар саналаа хураахгүй бол болохгүй байна. Энэ чинь энэ асуудлаасаа халиад гараад явчихлаа.

Гэхдээ Ганбат гишүүн ээ, үүнийг нээлттэй болгож байгаа бол, тэр ашиг сонирхлын зөрчилтэй шүүгчид байгаа бол, тэр буруу шийдвэр гаргаж байгаа улайм цайм үнэлэх ёстой нотлох баримтыг дүгнэхгүйгээр алгасаад

явчхаж байгаа эд нар чинь харин ийм нээлттэй шүүх дээр бүр ил гараад ирнэ шүү дээ. Хаашаа ч зугтах аргагүй. Тэр хүн үйлдлээрээ нөгөө тэрний хүн юм гэнэ лээ, ийм хүн юм гэнэ лээ. Тэр арын хаалганыхаа хүнийг хамгаалж байна гэж хэлэх боломжгүй болгож байгаа байхгүй юу. Энэ яг нээлттэй болгож байгаа чинь харин.

Тэгэхээр одоо яг та бидний баталж байгаа хууль таны ярьж байгаа энэ хардалтаас энэ хардалтыг 100 хувь арилгаж болох уу үгүй юу бүү мэд. Гэхдээ арилгах алхмыг харин бид нар зүгээр суухгүй хэдүүлээ яг хийгээд сууж байгаа юм.

Тэгээд ингээд санал хураалтаа үргэлжлүүлэе.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлэе. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдолтойгоор.

Төслийн 4 дүгээр зүйлийн “цахим шуудан” гэснийг “энэ хуулийн 59.12-т заасны дагуу гэж,” гэснийг хасаж, “шаардлагатай тохиолдолд” гэснийг “эсхүл” гэж тус тус” гэснийг “хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд” гэснийг “хүргүүлэх, эсхүл” гэж” гэж өөрчлөх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй 1 санал байгаа. Унишж танилцуулъя. Ер нь дөхөж байгаа.

Төслийн 5 дугаар зүйлийн “30 дугаар зүйлийн 30.4.4 дэх заалтын “байгууллага,” гэснийг,” гэснийг, “75 дугаар зүйлийн 75.2.6,” гэснийг тус тус хасаж, “50.4-т” гэсний өмнө “энэ

хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “байгууллагын нууц,” гэснийг “хэсгийг” гэснийг “хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийг” гэж өөрчилж 6 дугаар зүйлд шилжүүлэх. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлэе. 1 саналтай байгаа.

Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.” Санал хураалт. Жоохон үлдлээ шүү, манайхан.

Хэн Ганбат гишүүн саналаа.

Д.Ганбат: Бас л миний хуруунд байна уу. юунд байна. Тийм. Төхөөрөмж буруу заагаад байна. Дахин санал хураалгаж өгөөч ээ.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 7 дугаар зүйл санал хураалт дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй 1 санал байна. Түүнийг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 15.36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг” гэснийг хасах. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Нэг саналтай байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.5 дугаар зүйлийн 3 дахь

хэсгийн “ажиллагаанд хөтлөх” гэснийг “ажиллагааны” гэж, “байна” гэснийг “байж болно” гэж өөрчилж, 2 дахь заалтын 2.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “эрүүгийн” гэснийг “зөрчлийн” гэж, “хүргүүлнэ” гэснийг “хүргүүлж болно” гэж өөрчлөх:

“3.Хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн нэгдсэн цахим платформыг ашиглан явуулж болох бөгөөд хэргийн баримт бичиг, материал нь шүүхийн нэгдсэн цахим платформын шаардлагад нийцсэн байна.”. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн 1 санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй санал саналгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналгүй.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруул нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганбат гишүүн танилцуулчих. Тийм үү. Пүрэвдорж гишүүн ээ, та танилцуулчих уу? Энэ саяын юуг тийм.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж танилцуулна.

17.37 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцье.

Би уншаад юу яачихъя. Цагдаагийн албан тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулга хийнэ. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулъя.

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт цагдаагийн албан хаагчид дараах зүйлийг хориглоно гээд 69.1.8 дахь заалтад нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх. Албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх гэж заасны үйлдвэрчний эвлэлийн гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтын нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэснийг зөрчсөн байна.

2. Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх гэсний, үйлдвэрчний эвлэлийн гэснийг, мөн нам үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг гэсний үйлдвэрчний эвлэлийн гэж заасныг тус тус Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай гэсэн ийм цэцийн дүгнэлт гарсан байна.

Д.Цогтбаатар: Ингээд дууслаа итгэмж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Пүрэвдорж гишүүн, Ганбат гишүүн. Ганбат гишүүн микрофоныг нь өгье.

Д.Ганбат: Энэ цэц чинь ёстой сонин байна шүү дээ тийм ээ. Тэгээд 1 л

намтай юм шиг болчихсон л доо, Монгол Улс чинь. Тэгээд энэ үйлдвэрчний эвлэл чинь дандаа МАН-ын жагсаалтад орчихсон байна лээ шүү дээ. Тэр үйлдвэрчний эвлэлийн нөхдүүд, 1.

2-т, би цагдаа өнөөдөр бол погоонтой байгаа шүү дээ, мөрдөстэй байгаа, тангараг өргөж байгаа. Тэгээд ийм албан хаагчид чинь яаж ямар нэгэн нам, эвсэлд хамрагдах юм бэ? Тэр цагдаагийн дарга нь ч юм уу, хэн нэгэн тэгээд бараг л сүүлийн 8 жил бол дандаа л МАН-аас л томилогдож байгаа л даа. Гэхдээ бүр энэ чинь бүр илэрхий болох нь байна шүү дээ. Намын гишүүнээр элсээд нөгөө 30 жилийн өмнөх рүүгээ бараг орчихсон л доо. Социализмын үед ямар байсан бүгдээрээ л намын гишүүд, эвлэлийн гишүүд л байсан, нэг л намын. Одоо энэ чинь тэгээд бас тийм болох уу?

Уул нь 90 оны ардчилсан хувьсгалаас хойш бол энэ Үндсэн хууль гарсан. Энэ бүх юмаар бол тангараг өргөсөн цэргийн тангараг өргөсөн мөрдөстэй алба хаагч бол иргэдийнхээ эрх ашгийн төлөө л явах ёстой шүү дээ. Хууль сахиулах л үүрэгтэй. Тэгэхгүй бол бас нэг нам, эвслийн уриа яриад энд тэнд ингээд намын гишүүний хувьд тийм үүрэг хүлээж байна, ингэж шийдэж байна гээд. АН-ын ч юм уу, эсвэл энгийн иргэдийг бол үг хэлэхээр, жагсахаар тэд нарыг хааж боогоод зодож, нүдээд ингээд явуулчихдаг. МАН-ын гишүүд болохоор тэд нарыг дэмжсэн, Засгийн газрыг дэмжсэн ийм жагсаал цуглаан болохоор тэд нарыг бүр хамгаалж ингэж өгдөг. Уг нь бүгдийг нь л хамгаалж байх ёстой шүү дээ. Эмх замбараагүй байдал үүсгэхээс. Нэг ийм юм бий болчихсон. Түүнийг нь цэц бүр баталгаажуулж өгч байгаа юм уу, яаж байгаа юм? Би үүнийг асуумаар байх юм. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөсөө. Энэ одоо яг яаж шийдээд байгаа юм.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Цагдаагийн албаны тухай хууль бол 2017 оны 2 дугаар сард буюу өмнөх Улсын Их Хурлын чуулганы үед бол батлагдсан хууль байна. Энэ хуулийн 69.1.8 дахь буюу цагдаагийн албан хаагч нь үйлдвэрчний эвлэл, гишүүн, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн энэ заалтыг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан сая Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн байгаа.

Тэгээд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд энэ Үндсэн хуулийн зөрчөөгүй. Учир нь бол олон улсын хөдөлмөрийн байгууллага эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний 87 дугаар конвенцын тодорхой заалтуудын дагуу, 87 дугаар конвенцын 9.1 дээр энэ конвенцоор заасан баталгааг зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын хувьд ямар хэмжээгээр хэлж болохыг үндэсний хууль тогтоомжид тодорхойлно гэж заасан.

Тэгэхээр яг Монгол Улсын Их Хурлаас баталсан Цагдаагийн албаны тухай хууль яг энэ конвенцын дагуу тодорхой хүрээнд тодорхой хэмжээтэйгээр энэ конвенцыг хэрэглэх энэ эрхийнхээ дагуу энэ цагдаагийн байгууллага, хүчний байгууллагууд бол үйлдвэрчний эвлэлтэй байхыг хориглосон ийм агуулга оруулсан юм байна лээ. Үүнийг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан эвлэлдэн нэгдэх эрх ашгийг зөрчсөн гэдэг үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн.

Ер нь их олон улсад ялангуяа зэвсэг, аюулгүй байдал, цагдаагийн байгууллагын хувьд үйлдвэрчний эвлэл зэрэг тодорхой эвлэлдэн нэгдэх эрхэд хязгаар тавьсан ийм зохицуулалт бол үйлчилдэг. Энэ жишгээр энэ Цагдаагийн байгууллагын тухай хууль бол батлагдаж явсан гэж үзэж байгаа.

Цэцийн хуралдаан дээр яг манай энэ асуудлаар өргөдөл, гомдол гаргасан цагдаагийн байгууллагын албан хаагчид

хөдөлмөрлөх эрхтэй холбоотой нэлээн зөрчлүүд гардаг. Цалин, эсвэл ажлын болон амралтын өдрүүдэд ажиллуулсан тохиолдолд цалинг нөхөж олгохгүй зэрэг хөдөлмөрлөх эрхийн зөрчлүүд гардаг учраас үйлдвэрчний эвлэлийн байгууллагад нэгдэж байж бид нар энэ хөдөлмөрлөх эрхээ хангуулах нь зүйтэй гэдэг ийм нэхэмжлэл гаргасан байдаг. Энэ дагуу Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг гаргасан байна.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Яах вэ, бусад ардчилсан улс орнууд ямар байна? Энэ талаар бас харсан, үзсэн юм байна уу? Яах вэ цагдаа бол бусад улс орнуудад ихэнх нь мөрдөсгүй байна уу? Тийм байдаг байх. Хууль дээдэлж ажилладаг байх. Хэн нэгэн даргын тушаал гүйцэтгэдэггүй байх. Эхлээд мэдээж хэрэг тушаал гүйцэтгэх л хэрэгтэй л дээ. Одоо мөрдөстэй тангараг өргөсөн бол мэдлээ, гүйцэтгээ гэдэг үг хэлээд л тушаалыг бол хэлэлцдэггүй шүү дээ, биелүүлдэг шүү дээ. Тэгээд үүнийг харьцуулж харав уу? Ямар байна? Тийм.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ дэлхийн маш олон улс оронд тусгай буюу цагдаа хүчний байгууллагууд цэргийн байгууллагын үүрэгтэй холбоотойгоор эвлэлдэн нэгдэх эрхэд зарим нэг ийм хязгаарлалт тогтоож ирсэн байдаг юм байна. Ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах, дотоодын болон бусад гаднын түрэмгийллээс хамгаалах, тодорхой асуудлаарх улс төрийн нөхцөл байдлын үед тусгай үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахуйц ийм нөхцөлийг арилгах үүднээс эвлэлдэн нэгдэх асуудлыг бол ерөнхийдөө хязгаарласан байдаг.

Тийм учраас энэ олон улсын хөдөлмөрийн байгууллага тэр 1948 оны энэ конвенцоо хүний эрхийн 2 конвенц

болон сүүлд энэ 87 дугаар конвенц буюу яг эвлэлдэн нэгдэх эрхийн тухай конвенцдоо тусгайлан энэ зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын хувьд улс орон үндэсний дотоодын ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж тэгвэл асуулт асууж хариулт авч дууслаа. Санал хураалт явуулъя.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69.1.8 дахь заалтад “нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;” гэж заасны “... үйлдвэрчний эвлэлийн ..., үйлдвэрчний эвлэлийн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол...-ын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. А

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт дэмжигдсэнгүй.

27,3 хувиар асуудал дэмжигдсэнгүй. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны

санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн өөрөө танилцуулчих уу, болохгүй юу. Тэгэхээр чинь хэн байх вэ? Пүрэвдорж гишүүн танилцуулах уу? Тэгвэл Мөнхцэцэг гишүүн танилцуулна.

17.50 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгсөн санал байхгүй байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүн танилцуулчих уу.

Тэгвэл би өөрөө л танилцуулчихъя. Тэгье. Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүдээ талархал илэрхийлж байна.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ